



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020.10.19 № 25

Асуулга тавих тухай


Монгол улсын хөгжилд нөлөөлөгч олон хүчин зүйлсийн дотроос гадаад худалдаа, түүний бодлого, зохицуулалт, томоохон байр суурийг эзэлж ирсэн. Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлж, экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг өсгөхөд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүдээ бодлогоор дэмжиж, иргэдийн орлого, ажлын байрыг өсгөхөд гадаад худалдааны үүрэг оршино.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус салбарын экспортыг бодитой дэмжих, цаашлаад экспорт, импортын нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол экспорт” болон “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын талаар;
2. Гадаад худалдааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлууд ба цаашид хийгдэхээр төлөвлөж буй ажлуудын талаар;
3. Гадаад худалдааны бодлогын үр дүнг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох урсгал тэнцлийн алдагдал, экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс болон гадаад худалдааны бодлогын хэрэгслийг тодорхойлогч худалдааны гэрээ, хэлэлцээрийн ач холбогдол, хамгаалалтын хэмжүүр зэрэг үзүүлэлтүүд сүүлийн 10 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн талаар;
4. Япон улстай байгуулсан Чөлөөт худалдааны хэлэлцээр, мөн Европын холбооны Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системийн үр дүн, үнэлгээ, цаашид анхаарах асуудлуудын талаар;
5. Шинээр байгуулахаар судалж буй болон санал солилцсон Хөнгөлөлтийн ерөнхий систем, Чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийн явц байдал болон баримтлах бодлогын талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2020000071